



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.06 № 03/2067
танай _____-ны № _____-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102627 дугаартай "Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Тендерийн бичиг баримтын бараа нийлүүлэлтийн хуваарьт гэрээ байгуулснаас хойш 60 хоног гэж заасан байна. Гадаад улсад үйлдвэрлэгдэн импортоор ханган нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүний хувьд хамгийн багадаа 60 хоногийн хугацаанд үйлдвэрлэгдэж, тухайн улсаас 10-14 хоногт тээвэрлэгдэх бөгөөд, эцсийн хэрэглэгчийн гарт хүрэх хүрэл нийтдээ хамгийн багадаа 30-45 хоног зарцуулагддаг билээ. Тус тендерт санал болгож буй лабораторийн шинжилгээний тоног төхөөрөмжүүд нь гадаад улсад шинээр үйлдвэрлэгдэх, урьд өмнө нь ашиглагдаж байгаагүй, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг агуулсан байх юм. Иймд тендерийн ерөнхий шаардлагад байх бараа нийлүүлэлтийн хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 60 хоног гэж заасныг бараа нийлүүлэлтийн үед захиалагч талтай тохиролцон сунгаж болох эсэх тал дээр тодруулга өгч тусална уу</p>	<p>Бараа нийлүүлэлтийн хуваарьт гэрээ байгуулснаас хойш 60 хоног гэснийг гэрээ байгуулснаас 90 хүртэл хоног болгож байна.</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.